

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
САН

хагас
жилийн
тайлан

**БИД
ТҮҮЧЭЭЛЭХ
ЁСТОЙ**

**МАНДАЛ
ИРЭЭДҮЙН
ӨСӨЛТ**



Агуулга —

1. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА
2. САНГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТУХАЙ
4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ
5. ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
6. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ ЯВДЛУУД
7. САНГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД
8. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
9. ДОТООД ХЯНАЛТ
10. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
11. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

Монголын хөрөнгийн зэх зээлийн түүхэнд хамтдаа түүх бүтээлцэж буй эрхэм хөрөнгө оруулагч танд энэ өдрийн мэнд хүргэе!

Та бид хамтдаа банкны эзэд болох торгон мөч удахгүй тохиох нь ээ. Нөхцөл байдлыг харвал Төрийн банк энэ 8 сард IPO хийж, араас нь Голомт, Хаан банкнууд хувьцаагаа олон нийтэд санал болгохоор байна.

Мандал Ирээдүйн Өсөлт сангийн тухайд Банкны удирдлагуудтай гэрээ, хэлэлцээрийн түвшинд ажиллаж байна. Хамгийн чухал нь эрүүл засаглалтай, тогтвортой өсөлт үзүүлэх, эдийн засгийн цикл дагадаггүй банканд манай сан хөрөнгө оруулалт хийнэ.

Сан нь 7,000 гаруй хөрөнгө оруулагчтайгаар үйл ажиллагааг эхэлсэн. Бид одоо нэг жилийн босгоо давах гээд явж байна. Цаг хугацаа өнгөрөх тусам манай хөрөнгө оруулагчдын тоо нэмэгджээ.

Хөрөнгө оруулалтын сан бол эрсдэлийн удирдлага хамгийн өндөртэй. Энэ утгаараа бид эрсдэл багатай, эдийн засгийн цикл дагадаггүй салбарыг сонгон хөрөнгө оруулалт хийсээр байна.

Эцэст нь, эдийн засаг, нийгэм, улс төрийн хувьд ямар ч өөрчлөлт гарсан хөрөнгө оруулалтын сан нь ашиг хийх боломжтой байдаг нь бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс давуу талтай байдаг.

Хөрөнгө оруулагч та бидэнтэй урт хугацаанд хамт байж, сангийн ашиг орлогоо хамтдаа хүртэх нь чухал шүү.

Олны хүч, Оломгүй Далай

Г.Ганзориг

Г.ГАНЗОРИГ
Сангийн менежер

САНГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС нь эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх замаар олон нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг өөрийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн хүрээнд, мэргэжлийн түвшинд үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар үнэт цаасны зах зээлээс олсон өгөөжийг хөрөнгө оруулагчдадаа хүртээх зорилго бүхий мэргэжлийн хөрөнгө оруулалтын хуулийн этгээд юм.

Сангийн нэр	“Мандал Ирээдүйн Өсөлт” хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн хэлбэр	Хамтын
Сангийн төрөл	Хаалттай
Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа	10 жил
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	50 тэрбум төгрөг
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Мандал ассет менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө итгэмжлэн хадгалах	“Голомт Банк” ХХК – Кастодиан банкны хэлтэс
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч	“Мандал ассет менежмент ҮЦК” ХХК- 5%
Холбоо барих	Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамьян-Гүний гудамж, Меру тауэр-602 тоот
	Утас: +976 75759911
	Имэйл: support@mandalasset.mn

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Мандал санхүүгийн нэгдлийн охин компани болох Мандал Ассет Менежмент нь 2012 онд байгуулагдсан бөгөөд хөрөнгө оруулалтын менежмент, зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Бид эрсдэлийн удирдлагад суурилсан, урт хугацааны хөрөнгө оруулагч бөгөөд тогтвортой, стратегийн хөрөнгө оруулалтын боломжуудад төвлөрөн ажилладаг.

ХОМК-ийн нэр	“Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК
Байгуулагдсан	2012
Тусгай зөвшөөрөл	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа
Удирдаж буй хөрөнгө оруулалтын сангууд	“Мандал Мандал Праявит Экүити хувийн ХОС” ХХК “Мандал Хуримтлал хамтын ХОС” ХХК
Холбоо барих	Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамьян-Гүний гудамж, Меру тауэр-602 тоот
	Утас: +976-75759911
	Имэйл: support@mandalasset.mn

Монгол Улсын Шилдэг “Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компани”-аар шалгарлаа.

Дэлхийн банк санхүүгийн зах зээлийн томоохон төлөөлөгчдийн нэг болох “Global Banking and Finance Review” санхүүгийн сэтгүүлээс жил бүр зохион байгуулдаг “Global Banking and Finance Review Awards - 2022” шалгаруулалтад “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК нь тэргүүлж “Монгол Улсын Шилдэг Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компани”-аар Монгол Улсаас анх удаа шалгарлаа.

“Global Banking and Finance Review Awards” нь дэлхий даяар банк санхүүгийн салбарт манлайлагч шилдэг байгууллагуудыг шалгаруулдаг дэлхийд нэр хүндтэй шалгаруулалт юм.

“Монгол Улсын Шилдэг Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компани” хэмээх хүндтэй шагналын эзэн болсноор “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК үнэт цаасны зах зээлийн түүчээлэгч, зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчийн байр суурийг амжилттай бий болгож буй гэдгээ батлан харууллаа.

GLOBAL BANKING & FINANCE AWARDS® - 2022 - Award Winners

Award Category	Award Title	Award Winning Company	Country / Region
Banking & Finance Technology Awards	Best Banking Technology Implementation UK 2022	Lloyds Banking Group & Publicis Sapient	United Kingdom
Banking & Finance Technology Awards	Best Banking Technology Project UK 2022	Lloyds Banking Group & Publicis Sapient	United Kingdom

Fund & Asset management Awards Best Asset Management Company Mongolia 2022 Mandal Asset management Mongolia

Award Category	Award Title	Award Winning Company	Country / Region
Fund & Asset Management Awards	Islamic Asset Management Company of the Year 2022	KT Portfolio Asset Management Company	Turkey
Fund & Asset Management Awards	Most Innovative Investment Product (KFCMEGA) Thailand 2022	Krungsi Asset Management Co Ltd	Thailand
Fund & Asset Management Awards	Pension Fund Manager of the Year Thailand 2022	Krungsi Asset Management Co Ltd	Thailand
Fund & Asset Management Awards	Pension Fund Provider/ Manager Of the Year Brazil 2022	BNP Paribas Asset Management Brazil	Brazil
Fund & Asset Management Leadership Awards	Asset Management CEO of the Year Italy 2022	Dr. Ugo Loeser, Arca Fondi S.p.A.	Italy
Fund & Asset Management Product & Process Awards	Best Fund Management Product (Al Wataniya Investment Fund) MENA 2022	National Investments Company	Kuwait
Fund & Asset Management Product / Process Awards	Best Mutual Fund (Atlántico Liquidez) Angola 2022	Hemera Capital Partners PLC	Angola
Fund & Asset Management Product / Process Awards	Best Real Estate Fund Angola 2022	Hemera Capital Partners PLC	Angola



Эх сурвалж: www.globalbankingandfinance.com


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

Хөрөнгө оруулалтын сангийн багцын гол бүтээгдэхүүнийг банкны IPO-д оролцон бүрдүүлэхээр төлөвлөсөн хэдий ч банкууд нээлттэй компани болох хугацаа хойшилсонтой холбоотойгоор сангийн хөрөнгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу компанийн хувьцаа, өрийн хэрэгсэл болон мөнгөний зах зээлийн бүтээгдэхүүнээс сонгон эрсдэл багатай, өгөөж өндөртэйгөөр багц бүрдүүлэн удирдаж байна.

Банкны IPO хойшилсонтой холбоотойгоор сангийн нэгж эрхийн үнэ зах зээл дээр хэлбэлзэж байгаа ч цэвэр хөрөнгийн үнэ цэн тогтвортой өссөөр байна. Мөн системийн банкуудын IPO хийх ажил хүлээгдэж байх хугацаанд бид банкны удирдлагуудтай холбогдох уулзалтыг хэлэлцээрийн түвшинд тогтмол хийсээр байна.

Мөн, хөрөнгө оруулагчдынхаа дуу хоолой болон банкуудын IPO-г эхлүүлэх тал дээр зохицуулагч, бодлогын газруудтай хамтран ажиллаж байгааг дуулгамаар байна. Сан нь 2022 хагас жилийн буюу 2022 оны 06 дугаар сарын 30-ний байдлаар нийт 1.81 тэрбум төгрөгийн ашигтай, цэвэр хөрөнгийн үнэлгээ 53.7 тэрбум төгрөгт хүрлээ.

Нэгж эрхийн арилжааны мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Багцийн мэдээлэл




ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

I. Олон улсын нөхцөл байдал

2020 онд дэлхий дахиныг хамарсан цар тахлыг нөлөө үргэлжилсэн, Орос-Украины дайн, түүнтэй холбогдох санхүүгийн хориг зэрэг нь дэлхийн эдийн засагт ихээхэн нөлөөлж, түүхий эдийн болон хүнсний нийлүүлэлтийг тасалдсан зэрэг нь зах зээлд тогтворгүй байдлыг бий болгож, дэлхийн эдийн засгийн өсөлтийг удаашруулаад байна.

Түлш болон хүнсний үнийн өсөлт нь орлогын түвшин бага, хөгжиж буй орнуудад хүндээр нөлөөлж байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд 6.1% -аас 2022 болон 2023 онуудад 3.6%-д хүрч буурна хэмээн Олон Улсын Валютын Сангаас таамаглаж байна. Мөн дайны нөлөөллөөс үүссэн хүнсний үнийг өсөлт нь хөгжингүй орны инфлцын түвшинг 5.7%-д, харин хөгжингүй орнууд 8.7% хүргэж өсгөнө хэмээн төсөөлжээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт | хувиар



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн хэвийн төлөв 2022, Олон улсын валютын сан


2022 оны эхний хагас жил S&P500 индексийн хувьд 1970 оноос хойш хамгийн муу үзүүлэлтүүдийг үзүүлээ. Индексэд багтах компаниудын хувьд тогтмол ашиг орлогыг үзүүлсэн хэдий ч индекс уналттай байлаа.

II. Монголын хөрөнгийн зах зээлийн тойм

2022 оны эхний хагас жилд оны эхнээс Монголын хөрөнгийн бирж дээрх ТОП-20 индекс 25%, MSE A индекс 20%, MSE B 6%-ийн бууралт үзүүлжээ.


МХБ дээр нийт ₮275.9 тэрбум арилжаа хийгджээ. Үүний 36.93 %-ийг бондын арилжаа, 41.2 %-ийг хувьцааны арилжаа, 0.85 %-ийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа, 21.01 %-ийг ХБҮЦ-ны арилжаа бүрдүүлсэн байна.

Монголын хөрөнгийн зах зээлийн индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Монголын хөрөнгийн зах зээлийн арилжаа



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

I. Анхны нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулагдлаа

“Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК нь Монголын анхны нээлттэй хөрөнгө оруулалтын сан болох “Мандал Хуримтлал хамтын ХОС” ХХК-г байгуулж, сангийн нэгж эрхийн танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 209 тогтоолоор бүртгүүллээ.

Мөн цаашлаад сан нь анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явуулснаар, дотоодын үнэт цаасны зах зээл хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй анхны нээлттэй сан болон байгуулагдлаа.

Сан нь нэгж эрхээ бусдад худалдахаар санал болгож, түүнчлэн эрэлтийн хэмжээгээрээ нэгж эрх нэмж гаргадаг онцлогтой. Энэ нь манай улсын хөрөнгийн зах зээл дээр гарч буй цоо шинэ бүтээгдэхүүн юм.

Түүнчлэн мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хамтран эрсдэл багатай, өндөр өгөөжтэй хуримтлалыг үүсгэх боломжийг хөрөнгө оруулагчдад бий болгож байгаагаараа давуу талтай юм.



II. Хамгийн өндөр үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зах зээлд гарав

Нийтэд санал болгон гаргах хамгийн өндөр дүнтэй буюу “Симпл ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 6 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд хийгдэж нийт 50 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 251 хөрөнгө оруулагчаас амжилттай татан төвлөрүүлж чадсан байна. “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК болон “Мандал капитал маркетс ҮЦК” нь тус ХБҮЦ-ны андеррайтерээр ажиллаа.



III. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хууль, эрх зүйн орчин

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь Иргэний хууль, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж болон Санхүүгийн Зохицуулах хорооноос тогтоосон эрхийн бусад актыг мөрдөж үйл ажиллагаа явуулдаг.

IV. Хөрөнгө оруулалтын сангийн болон Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлалаа

Санхүүгийн Зохицуулах хорооны журмын хувьд: Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 275 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам” мөн 276 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” тус тус шинэчлэгдэн батлагдсан.

Уг журмуудыг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхлэх тул Сангийн дотоод дүрэм, журам, хөрөнгийн хэмжээ, бүтэц зохион байгуулалт зэргийг хууль эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөхөөр ажиллаж байна.

V. Банкуудын IPO гаргах хугацаа нэг жилээр сунгалаа

Банкны тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжих явцад Монголбанк болон Олон улсын валютын сангаас тавьсан шаардлага, дүгнэлтийн хүрээнд нээлттэй хувьцаат компани болох эцсийн хугацааг 2023 оны 06 сарын 30-ны өдөр хүртэл сунгаад байгаа билээ.

Энэ нь Банкны системд хийгдэж буй Реформыг илүү чанартай, илүү далайцтай болгоход чиглэсэн гэж ойлгож байгаа. Процессын хувьд системийн ТОП5 банк дээр AQR буюу Активын чанарын үнэлгээг хийлгэж эхэлсэн. Энэ нь банкуудын зээлийн чанарыг үнэлэх зорилготой бөгөөд банк тус бүр дээр 40 зээлийг сонгон шалгаж байна. Гэхдээ энэхүү шалгалт шувтрах шатандаа ороод байна.



САНГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

I. Хөрөнгө оруулалтын экспо амжилттай зохион байгуулагдаж, “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС”-ийн хөрөнгө оруулагчид хурлаа хийн чууллаа

Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан нь 2022 оны 4 сарын 23-ны өдөр Санхүүгийн Зах Зээлийн Холбоо НҮТББ-тай хамтран Хөрөнгө оруулалтын экспог зохион байгуулсан. Хөрөнгө оруулалтын экспод нийт 10,000 хөрөнгө оруулагч бүртгүүлж хамрагдаж, хөрөнгийн зах зээлийн мэдээ, мэдээллийг нэг дороос хүлээн авсан билээ. Экспогоор “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС”-ийн нэгж эрх эзэмшигчдийн хурал зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцэж баталлаа.

- Сангийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан;
- Кастодианд хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;
- Сангийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
- Сангийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэр;
- ТУЗ-ийн 2022 үйл ажиллагааны зардлын төсөв;

Энэхүү экспод хөрөнгө оруулалтын боломжуудыг нэг цэгт төвлөрүүлж мэдээллээр хангах, олон нийтийг хөрөнгийн зах зээлийн мэдлэг, мэдээллээр хангасан юм. “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК, “Сентрал Экспресс Си Ви Эс” ХК, “Монос Хүнс” ХК, “Мандал Даатгал” ХК, болон “Түмэн Шувуут” ХК зэрэг нийт 5 компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зэрэг болж өндөрлөсөн түүхэн үйл явдал байлаа.

investment
expo
by MANDAL

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭКПОД

10 000

ХҮН ОРОЛЦЛОО



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Сангийн ТУЗ нь хамтын удирдлага бүхий бүтэцтэй бөгөөд тогтмол хуралдаж Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, Санг үр ашигтай шийдвэр гаргах, үйл ажиллагааг хянах, стратегийг тодорхойлох үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Сангийн ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба ТУЗ-ийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүйгээр, хараат бусаар Сангийн Нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажилладаг. Сангийн ТУЗ-ийн гишүүд нь банк, даатгал, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбарт ажиллаж байсан арвин туршлага, чадвартай болно.

	Хурлын гишүүд	Албан тушаал	
1	Ө.Ганзориг	ТУЗ-ийн дарга	Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК, ТУЗ-ийн дарга
2	Н.Монсор	ТУЗ-ийн гишүүн	Мандал Ассет Менежмент ҮЦК ХХК, ТУЗ-ийн гишүүн
3	Ч.Даваадаш	ТУЗ-ийн гишүүн	Мандал Даатгал ХК
4	Ц.Батсүх	ТУЗ-ийн хараат бус гишүүн	СЭЗИС-ийн Экономиксийн тэнхимд профессор
5	Ч.Анхбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	МУИС, БС-ийн санхүүгийн тэнхим, ахлах багш

ДОТООД ХЯНАЛТ

Дотоод хяналтын үйл ажиллагааны тайлан нь Сангийн дотоод хяналтын журамд заасны дагуу дотоод хяналтын хорооны ажиллах зарчим, хяналт шалгалтын хамрах хүрээ, дотоод хяналтын хорооны гишүүдийн эрх, үүрэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах төдийгүй үнэлэлт дүгнэлт өгөхөд оршдог юм.

Сангийн ТУЗ нь дэргэдээ дотоод хяналтын хороотой бөгөөд дотоод хяналтын хороо нь сангийн үйл ажиллагаанд болон сангийн менежерийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх, кастодианы үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг билээ. Тус дотоод хяналтын хороо нь Сангийн ТУЗ-с томилогдож, өөрийн үйл ажиллагааг Сангийн ТУЗ-д тогтмол тайлагнадаг. Дотоод хяналтын хороо нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, энэ чиглэлээр ажилладаг туршлагатай дараах гурван (3) гишүүнтэй. Үүнд:

Г. Гантулга - Дотоод хяналтын хорооны дарга
Б.Энхтүвшин - Дотоод хяналтын хорооны гишүүн
Г.Батзориг - Дотоод хяналтын хорооны гишүүн

Дотоод хяналтын хороо нь хяналтыг төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус хэлбэрээр явуулдаг. Төлөвлөгөөт хяналтыг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас жилд нэг удаа батлах бөгөөд Дотоод хяналтын хороо нь уг төлөвлөгөөнд заасан хугацаанд хяналт шалгалтын үйл ажиллагааг гүйцэтгэх юм. Төлөвлөгөөт бус хяналтыг дараах тохиолдолд явуулна.

Үүнд:

- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлаар дотоод хяналт явуулах шаардлагатай гэж үзсэн.
- Дотоод хяналтын хороо дотоод хяналт явуулах шаардлагатай гэж үзсэн.

2022 оны нэгдүгээр хагас жилийн хугацаанд дотоод хяналтын хорооны төлөвлөгөөт бус хяналт хийх шаардлага үүсээгүй хэмээн үзсэн байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРСДЭЛ

Сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх тул нийгэм эдийн засаг, санхүү болон үйл ажиллагааны эрсдэлүүдийг удирдах шаардлага тулгарна. Тиймээс компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлдэг.

Тухайлбал ажилтан, хэлтэс болон сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тогтмол тодорхойлох, үнэлэх, бууруулах нь эрсдэлийг оновчтой удирдах гол аргачлалын нэг юм. Эрсдэлийг удирдах доорх бүтцээр ХОМК нь сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой бүхий л нөхцөл байдлыг үнэлж дүгнэдэг.

Үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийн удирдлагын талаарх ойлголтыг нэвтрүүлэхийн сацуу ажилтан бүр энэ талын мэдлэгээ тогтмол дээшлүүлж ажиллахыг эрхэмлэдэг. Эрсдэлийн бодлогын хүрээнд дараах эрсдэлүүдийг түлхүүр болгон тодорхойлж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.

I. Хөрөнгө оруулалтын эрсдэл

Хөрөнгө оруулалтын эрсдэлийн хүрээнд багцын эрсдэлийг тооцож, тараан байршуулалт хийдэг. Хөрөнгө оруулалтын судалгаанд эрсдэлийн үнэлгээг заавал тооцдог ба эрсдэлийн удирдлагын олон жилийн туршлагатай баг хамт олон хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргадаг.

• Хүүгийн түвшний эрсдэл

Зах зээл дэх хүүгийн түвшин өөрчлөгдөх нь Сангийн мөнгөн хөрөнгийн хадгаламжийн өгөөжийн түвшинд нөлөөлнө. Иймд хүүгийн түвшний өөрчлөлт таамаглалыг улирал бүр шинэчилж, тогтвортой үйл ажиллагаатай, эрсдэл даах чадвар өндөр банкийг харилцагчаар сонгож ажиллана.

• Инфляцын эрсдэл

Сангийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаас олох өгөөж нь ирээдүйн инфляцын түвшин, мөнгөний үнэ цэний утгаас хамааран бодит утгаараа төлөвлөсөн хэмжээнээс бага байх эрсдэл бий.

Инфляцын өсөлт нь эдийн засгийн бусад хүчин зүйлст нөлөөлөх ба үнэт цаасны бодит үнэ цэнд нөлөөлнө. Сан нь инфляц, эдийн засгийн загварын таамаглал ашиглан ирээдүйн инфляцын түвшинг тооцон ажиллана.

• Валютын ханшийн эрсдэл

Ханшийн хэлбэлзэл нь зах зээлд тодорхой бус байдлыг нэмэгдүүлж эдийн засгийн үйл хөдлөлийн зардлыг ихэсгэдэг. Иймд ханшийн таамаглал эрсдэлийг тооцон ажиллана. Үйл ажиллагааны эрсдэл Сан үйл ажиллагаа явуулахад хүний нөөц, ашиглаж буй систем дотоод дүрэм журам болон зах зээлээс нөлөөлж болохуйц үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд хамаарна.

Тухайлбал хүнээс хамаарах үйл ажиллагааны алдаа, технологийн доголдол болон хууль эрх зүйтэй холбоотой эрсдэлүүд багтдаг. ХОМК-ийн хүний нөөцийн эргэц бага, олон жилийн туршлагатай мэргэжилтнээс бүрдэж байгаа нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах түлхүүр болж байна.

• Зах зээлийн эрсдэл

Сангийн удирдаж буй хөрөнгийн үнэлгээ эдийн засаг, улс төр, санхүү болон нийгмийн эрүүл мэндтэй холбоотой (халдварт өвчин, цар тахал гэх мэт) эсхүл зах зээлд өрнөж буй үйл явдлаас шалтгаалан өсөх, буурах зэрэг хэлбэлзэж болно. Дээрх дурдсан үйл явдлаас шалтгаалсан гэнэтийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах, төсөөлөх нь хүнд сорилт байдаг.

ХОМК нь нийгэм эдийн засгийн өдөр тутам хувьсан өөрчлөгдөж буй орчинд тохируулан богино хугацаанд хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны оновчтой шийдвэрүүдийг судалгаа шинжилгээнд суурилан ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 7,000 гаруй нэгж эрх зэмшигчдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор “Үнэт цаасны зах зээлийн ойлгох нь” сэдэвт онлайн сургалтыг зохион байгуулж, тус сургалтын агуулгыг бататгах зорилгоор сургалтад хамрагдсан хөрөнгө оруулагч бүрт “Санхүүгийн философи” номыг бэлэглэсэн билээ.

“Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн фейсбүүк хуудсаар дамжуулан хөрөнгийн зах зээлийн мэдээлэл бүхий контентыг тогтмол боловсруулан хүргэж байна. Сан нь дараах аж ахуйн нэгжүүдийн албан хаагч, ажилчдад хөрөнгийн зах зээлд мэдлэг олгох сургалтыг тогтмол зохион байгуулж байгаа билээ. Үүнд:

- Нэкст групп
- Баясах групп
- Оюутолгой
- Монложистикс групп

М-Си-Эс групп:

- Анунгоо
- Юнител
- М Си Эс Эстэйтс
- М-Армор
- Тотал Дистрибьюшн
- Эрчим сүлжээ
- Ашид Капитал ББСБ
- Скай Резорт
- Интермед Медикал
- Анун
- М-Си-Эс Кока Кола
- Топ Моторс

Мөн “Эдийн засгийн сэтгүүлчдийн клуб”-ын сэтгүүлчдэд хөрөнгийн зах зээл, макро эдийн засгийн мэдээлэл олгох сургалтыг улирал тутамд зохион байгуулж байна.

Бизнес, менежментийн 1 сарын сургалтын үйл ажиллагаа явуулаг Ганзориг Бизнес Скүүл-ийн Менежментийн Психологи, Санхүүгийн Философи, Борлуулалтын Менежмент, Төслийн Менежмент Бизнес, Процесс Менежмент зэрэг сургалтуудад хөнгөлөлттэй үнээр хамрагдах боломжийг олгодог.

Мандал Санхүүгийн Нэгдлийн дэргэдэх Дэлхийн санхүүгийн түүхийн музейг 2022 оны 01 сараас эхлэн Мандал Ирээдүйн Өсөлт сангийн нийт 7,000 хөрөнгө оруулагчдад үнэ төлбөргүй, бүрэн тайлбартай үзүүлж байна.

Мөн Сангийн хөрөнгө оруулагчдад утсаар болон биечлэн уулзалт хийн шаардлагатай хөрөнгө оруулалт болон санхүүгийн зөвлөх үйлчилгээг тухай бүрд үзүүлж байна.



MANDAL
ASSET

Таны хөрөнгө оруулалтын менежер

7575-9911

mandalasset.mn



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

1	Үзүүлэлт	Мянган төгрөг	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 6-р сарын 30
1.1	Хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,027,619.74	8,260,011,067.16
1.1.3	Дансны авлага	0.00	0.00
1.1.4	Татвар, НДШ – ийн авлага	0.00	0.00
1.1.5	Бусад авлага	427,008,107.42	495,995,001.26
1.1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	3,554,830,949.03	19,075,278,747.96
1.1.7	Бараа материал	0.00	0.00
1.1.8	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	985,305,525.00	985,305,525.00
1.1.11	Бусад эргэлтийн хөрөнгө	46,157,125,073.73	24,008,393,219.53
1.2.1	Эргэлтийн хөрөнгийн дүн	51,128,297,274.92	52,824,983,560.91
1.2.2	Үндсэн хөрөнгө	0.00	0.00
1.2.3	Биет бус хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.5	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.6	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	45,456,633.96	45,267,006.45
1.2.8	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.3	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	45,456,633.96	45,267,006.45
2.1.1.1	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	51,173,753,908.88	52,870,250,567.36
2.1.1.2	Дансны өглөг	0.00	0.00
2.1.1.3	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.4	Татварын өр	46,314,465.31	52,782,180.07
2.1.1.5	НДШ - ийн өглөг	0.00	0.00
2.1.1.6	Банкны богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.7	Хүүний өглөг	0.00	500.00
2.1.1.8	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.9	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.10	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.13	Бусад богино хугацаат өр төлбөр	125,955,230.03	0.00
2.1.2.1	Богино хугацаат өр төлбөрийн дүн	172,269,695.34	52,782,180.07
2.1.2.2	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.3	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.4	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.6	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.3	Өр төлбөрийн нийт дүн	172,269,695.34	52,782,180.07
2.3.1	Өмч	50,000,000,000.00	50,000,000,000.00
2.3.2	төрийн	0.00	0.00
2.3.3	хувийн	50,000,000,000.00	50,000,000,000.00
2.3.4	хувьцаат	0.00	0.00
2.3.5	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.6	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.7	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.8	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.9	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	1,896,275.11
2.3.11	Хуримтлагдсан ашиг	1,001,484,213.54	2,815,572,112.18
2.4	Эздийн өмчийн дүн	51,001,484,213.54	52,817,468,387.29
2.3.9	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	51,173,753,908.88	52,870,250,567.36
2.3.10	Эздийн өмчийн дүн	51,001,484,213.54	52,858,139,885.97
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	51,173,753,908.88	52,910,922,066.04

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Мянган төгрөг	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 6-р сарын 30
1	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	0.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
3	"Нийт ашиг (алдагдал)	0.00	0.00
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	1,081,229,182.56	2,074,373,802.07
6	Ногдол ашгийн орлого	0.00	5,756,068.88
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	404,783,955.76	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	418,248,985.92	388,517,157.59
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	316,687,426.62
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	-7,650,556.55
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	"Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,067,764,152.40	2,000,649,583.43
19	Орлогын татварын зардал	66,279,938.86	186,561,684.79
20	"Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	1,001,484,213.54	1,814,087,898.64
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	"Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,001,484,213.54	1,814,087,898.64
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	"Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	1,001,484,213.54	1,814,087,898.64
25	"Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

ӨМЧИЙН ӨӨРЧӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Өмч хувицаа	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Мянган төгрөг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
2	Нягтлан бодох бүртгэлийн борлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
3	Залруулсан үлдэгдэл	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	0.	0.	0.	1,001,484,213.54	1,001,484,213.54	1,001,484,213.54
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
6	Өмчид гарсан өөрчлөлт	50,000,000,000.	0.	0.	0.	0.	0.	0.	50,000,000,000.	50,000,000,000.
7	Зарласан ногдол ашиг	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,000,000,000.	0.	0.	0.	0.	0.	1,001,484,213.54	51,001,484,213.54	51,001,484,213.54
10	Нягтлан бодох бүртгэлийн борлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
11	Залруулсан үлдэгдэл	50,000,000,000.	0.	0.	0.	0.	0.	1,001,484,213.54	51,001,484,213.54	51,001,484,213.54
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	0.	0.	0.	1,814,087,898.64	1,814,087,898.64	1,814,087,898.64
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	0.	0.	0.	1,896,275.11	0.	1,896,275.11	1,896,275.11
15	Зарласан ногдол ашиг	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,000,000,000.	0.	0.	0.	0.	1,896,275.11	2,815,572,112.18	52,817,468,387.29	52,817,468,387.29

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	Мянган төгрөг	
			2022 оны 6-р сарын 30	2022 оны 6-р сарын 30
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	0.00
1.1	"Мөнгөн орлогын дүн"	0.00	0.00	0.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	0.00	0.00
1.1.2	"Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00	0.00
1.1.3	"Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00	0.00
1.1.4	"Буцаан авсан албан татвар	0.00	0.00	0.00
1.1.5	"Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00	0.00
1.1.6	"Бусад мөнгөн орлого	0.00	0.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,277,576,980.89	488,208,614.50	488,208,614.50
1.2.1	Ажиллагчдад төлсөн	0.00	0.00	0.00
1.2.2	"Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.00	0.00	0.00
1.2.3	"Бараа материал худалдан авахад төлсөн	0.00	0.00	0.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	0.00	0.00	0.00
1.2.5	"Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	0.00	0.00
1.2.6	"Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00	0.00
1.2.7	"Татварын байгууллагад төлсөн	0.00	0.00	0.00
1.2.8	"Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00	0.00
1.2.9	"Бусад мөнгөн зарлага	1,277,576,980.89	488,208,614.50	488,208,614.50
1.3	"Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн"	-1,277,576,980.89	-488,208,614.50	-488,208,614.50
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	0.00
2.1	"Мөнгөн орлогын дүн"	43,966,186,589.93	140,852,298,917.55	140,852,298,917.55
2.1.1	"Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	10,085,708,147.00	10,085,708,147.00
2.1.2	"Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	0.00
2.1.3	"Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	43,944,017,755.39	130,424,427,762.52	130,424,427,762.52
2.1.4	"Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	0.00
2.1.5	"Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00	0.00
2.1.6	"Хүлээн авсан хүүний орлого	22,168,834.54	336,982,546.03	336,982,546.03
2.1.7	"Хүлээн авсан ногдол ашиг	0.00	5,180,462.00	5,180,462.00
2.2	"Мөнгөн зарлагын дүн"	86,629,755,999.33	132,073,812,118.45	132,073,812,118.45
2.2.1	"Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	0.00
2.2.2	"Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	0.00
2.2.3	"Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	86,629,755,999.33	121,646,265,212.51	121,646,265,212.51
2.2.4	"Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	10,427,546,905.94	10,427,546,905.94
2.2.5	"Бусад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00	0.00
2.3	"Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн"	-42,663,569,409.40	8,778,486,799.10	8,778,486,799.10
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00	0.00
3.1	"Мөнгөн орлогын дүн"	47,500,004,000.00	0.00	0.00
3.1.1	"Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,000.00	0.00	0.00
3.1.2	"Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	47,500,000,000.00	0.00	0.00
3.1.3	"Төрөл бүрийн хандив	0.00	0.00	0.00
3.2	"Мөнгөн зарлагын дүн"	3,554,829,989.97	353,007,244.80	353,007,244.80
3.2.1	"Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,554,829,989.97	0.00	0.00
3.2.2	"Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	353,007,244.80	353,007,244.80
3.2.4	"Төлсөн ногдол ашиг	0.00	0.00	0.00
3.3	"Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн"	43,945,174,010.03	-353,007,244.80	-353,007,244.80
4	"Валютын ханшийн зөрүү"	0.00	318,712,507.62	318,712,507.62
4.1	"Бүх цэвэр мөнгөн гүйлгээ"	4,027,619.74	8,255,983,447.42	8,255,983,447.42
5	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл"	0.00	4,027,619.74	4,027,619.74
6	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл"	4,027,619.74	8,260,011,067.16	8,260,011,067.16

Утас: +976-75759911
Имэйл: support@mandalasset.mn